

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дүгээр  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### ОРОН СУУЦНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### **1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь орон сууц хөгжүүлэх үйл ажиллагаа, орон сууцны ашиглалтыг сайжруулах оновчтой тогтолцоог бүрдүүлэх замаар сууц өмчлөгчийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл, эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааг төрөөс хангахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

#### **2 дугаар зүйл.Орон сууцны тухай хууль тогтоомж**

2.1.Орон сууцны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, Иргэний хууль, Барилгын тухай хууль, Газрын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Хот, суурини ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Орон сууц хувьчлах тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### **3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцыг буулган шинээр барихтай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулиар, орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй холбоотой энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хот байгуулалтын тухай хуулиар тус тус зохицуулна.

3.2.Мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрөлтэй холбогдсон харилцааг Хот, суурини ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай, Эрчим хүчний тухай, Харилцаа холбооны тухай хуулиудаар, олон айлын орон сууцны орчны газартай холбогдох харилцааг Газрын тухай хуулиар тус тус зохицуулна.

#### **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."орон сууц" гэж хүн суурьшин амьдрах зориулалттай нэг болон олон айлын сууцны барилгыг;

4.1.2."суүц" гэж орон сууцны барилга дахь нэг өрх амьдрах зориулалттай, нэг буюу хэд хэдэн өрөө бүхий цогцолборыг;

4.1.3."олон айлын орон сууц" гэж нийтийн зориулалттай хоёр буюу түүнээс дээш сууцны барилгыг;

4.1.4."орчны газар" гэж тухайн орон сууц, гэр хорооллын оршин суугчдад зориулагдсан ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, сүүдрэвч, гэрэлтүүлэг, явган хүний зам, гарц, автозам, автомашины нийтийн зогсоол, тэдгээртэй адилтгах байгууламж бүхий газрыг;

4.1.5."орон сууц хөгжүүлэх үйл ажиллагаа" гэж орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, түүний дэд бүтцийг сайжруулах, хөгжүүлэх арга хэмжээг;

4.1.6."орон сууц өмчлөгч, сууц өмчлөгч" гэж тухайн орон сууцыг захиран зарцуулах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг;

4.1.7."хэрэглэгч" гэж Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 3.1.1, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 3.1.13, Эрчим хүчний тухай хуулийн 3.1.19, Харилцаа, холбооны тухай хуулийн 3.1.6-д заасан иргэн, хуулийн этгээдийг;

4.1.8."оршин суугч" гэж тухайн сууцанд байнга болон түр оршин сууж буй сууц өмчлөгч, эсхүл түрээслэх, хөлслөх болон бусад гэрээний үндсэн дээр оршин сууж буй этгээдийг;

4.1.9."мэргэжлийн байгууллага" гэж энэ хуулийн 16.1-д заасан үйлчилгээг эрхлэхээр, энэ хуулийн 15.2-т заасан гэрээг байгуулсан хуулийн этгээдийг;

4.1.10."сууц өмчлөгчид ногдох хэсэг" гэж орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, засвар, үйлчилгээтэй холбогдох зардлыг санхүүжүүлэхэд тухайн сууц өмчлөгчийн оролцох хувь хэмжээг;

4.1.11."түрээсийн орон сууц, сууц" гэж түрээсийн гэрээний үндсэн дээр ашиглаж байгаа орон сууцны барилга, сууцыг;

4.1.12."түгээх шугам сүлжээ" гэж Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 3.1.7, Харилцаа холбооны тухай хуулийн 3.1.1, 3.1.2, Эрчим хүчний тухай хуулийн 3.1.14, 3.1.8-д заасан шугам сүлжээг;

4.1.13."сууц өмчлөгчдийн холбоо" гэж орон сууцны ашиглалт, орон сууц, гэр хорооллын орчны газрын тохижилтыг сайжруулах зэргээр өөрсдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор сайн дураараа эвлэлдэн нэгдсэн, Иргэний хуулийн 481 дүгээр зүйлд заасны дагуу зохион байгуулагдсан оршин суугчдын бүртгэгдээгүй холбоог;

4.1.14."сууц өмчлөгчдийн дундын өмчлөлийн эд хөрөнгө" гэж Иргэний хуулийн 142 дугаар зүйлд заасныг;

4.1.15."орон сууцны хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөө" гэж хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу

тухайн нутаг дэвсгэрт орон сууц, түүний дэд бүтэц, орчны тохижилт, ногоон байгууламж, нийгмийн үйлчилгээний барилга, байгууламжийг иж бүрнээр нарийвчлан тодотгож төлөвлөсөн хот байгуулалтын үйл ажиллагааны баримт бичгийг.

## **5 дугаар зүйл.Төрөөс орон сууцны талаар баримтлах зарчим**

### **5.1.Төрөөс орон сууцны талаар дараах зарчмыг баримтална:**

5.1.1.иргэдийг эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан орон сууцаар хангах нөхцөлийг бүрдүүлэх;

5.1.2.орон сууцны хороолол, түүний дэд бүтцийг хот байгуулалтын баримт бичигт үндэслэн төлөвлөх, барьж байгуулах;

5.1.3.байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй орон сууцыг дэмжих;

5.1.4.зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулахад дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх;

5.1.5.гэр хорооллын газрыг дахин төлөвлөн хөгжүүлэх;

5.1.6.орон сууцны ашиглалтыг сайжруулах оновчтой тогтолцоог бүрдүүлэх;

5.1.7.хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, бодлогоор дэмжих.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ОРОН СУУЦНЫ ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЧИГ ҮҮРЭГ**

### **6 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх**

#### **6.1.Улсын Их Хурал орон сууцны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:**

6.1.1.орон сууц, түүний дэд бүтцийг хөгжүүлэхэд төрөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг тогтоох;

6.1.2.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

### **7 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх**

#### **7.1.Засгийн газар орон сууцны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:**

7.1.1.хүн амьг орон сууцаар хангах төрийн бодлогыг тодорхойлох, уг бодлогын хүрээнд орон сууц, түүний дэд бүтцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

7.1.2.зорилтот бүлгийн иргэдэд орон сууцны дэмжлэг үзүүлэх журмыг батлах;

7.1.3.орон сууцны санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээ авах;

7.1.4.гадаадын зээл, тусlamжийн хөрөнгөөр орон сүүц барих, засварлах асуудлыг бодлогын хувьд шийдвэрлэх;

7.1.5.зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах бодлогыг хэрэгжүүлэх төрийн өмчт хуулийн этгээдийг байгуулах, үйл ажиллагааны дүрмийг батлах;

7.1.6.төрийн өмчийн түрэсийн орон сууцны санг бүрдүүлэх, ашиглахад шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх;

7.1.7.орон сууцны талаарх хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах.

**8 дугаар зүйл.Орон сууцны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг**

8.1.Орон сууцны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага орон сууцны талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.1.1.төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого, орон сууц, түүний дэд бүтцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих;

8.1.2.зорилтот бүлгийн иргэдэд орон сууцны дэмжлэг үзүүлэх журмын төслийг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;

8.1.3.орон сууцны төлөвлөлт, ашиглалтын норм, дүрэм батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

8.1.4.мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага, үйл ажиллагаа явуулах эрх олгох сонгон шалгаруулалтын журам батлах;

8.1.5.төрийн болон орон нутгийн өмчийн орон сууцыг түрээслэх төлбөрийг иргэдийн амьжиргааны түвшинтэй уялдуулан тогтоох;

8.1.6.төрийн өмчийн түрэсийн орон сууцанд иргэдийг хамруулах журмыг батлах;

8.1.7.улсын бүртгэлийн мэдээллийн санд сууриссан орон сууцны төрөлжсэн мэдээллийн сангийн журам батлах.

**9 дүгээр зүйл.Орон сууцны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг**

9.1.Орон сууцны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.1.1.төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулах;

9.1.2.орон сууцны төлөвлөлт, ашиглалтын норм, дүрэм, журам, стандартын төсөл боловсруулах, хэрэгжүүлэх;

9.1.3.аймаг, нийслэлийн Засаг дарга мэргэжлийн байгууллагатай байгуулах гэрээний жишиг загварыг боловсруулж, батлах;

9.1.4.орон сууцны төрөлжсөн мэдээллийн санг эрхлэн хөтлөх, сангаас иргэн, байгууллагыг мэдээ, мэдээллээр хангах;

9.1.5.мэргэжлийн байгууллага, хэрэглэгчийн хооронд байгуулах гэрээний нөхцөл, шаардлагыг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих.

---

**10 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын чиг үүрэг**

10.1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон сууцны талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.1.1.нутаг дэвсгэртээ орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, Чанарыг сайжруулах болон зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах бодлогыг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих;

10.1.2.Засаг даргын өргөн мэдүүлснээр нутаг дэвсгэртээ орон сууцны хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөө, орон сууцны дэд хөтөлбөрийг батлах;

10.1.3.орон сууц хөгжүүлэх үйл ажиллагаанд аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс зарцуулах хөрөнгийг хэлэлцэж батлах;

10.1.4.орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх хөрөнгийг шийдвэрлэх, орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцанд иргэдийг хамруулах журмыг батлах;

10.1.5.энэ хуулийн 10.3.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх талаар гүйцэтгэсэн ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх;

10.2.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон сууцны талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.2.1.нутаг дэвсгэрийн хөгжлийн дунд хугацааны бодлого, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд орон сууцны талаарх асуудлыг тусган батлах;

10.2.2.Засаг даргын өргөн мэдүүлснээр сум, дүүргийн орон сууцны төсвийг хэлэлцэж батлах, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлах.

10.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга орон сууцны талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.3.1.нутаг дэвсгэртээ орон сууцны хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөөний төслийг боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

10.3.2.энэ хуулийн 19.3-д заасан эд хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэж авах;

10.3.3.энэ хуулийн 10.3.2-т заасан өмчийг ашиглахтай холбогдсон зардлыг үндсэн хөрөнгийн элэгдлийн хуримтлал болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх;

10.3.4.орон сууц хөгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилтийг шийдвэрлүүлэх;

10.3.5.тухайн жилийн төсвийн хуульд нийцүүлэн орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх, нэмэгдүүлэх хөрөнгийг шийдвэрлүүлэх;

10.3.6.мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны талаар хэрэглэгчийн гаргасан гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах нэгдсэн төвийн үйл ажиллагаанд нь хяналт тавих;

10.3.7.энэ хуулийн 15.1-д заасан сонгон шалгаруулалтад оролцох хуулийн этгээд орон сууцны барилга, байгууламжийн ашиглалттай танилцах боломжоор хангах;

10.3.8.хууль тогтоомжид заасны дагуу орон сууцанд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих.

10.4.Сум, дүүргийн Засаг дарга орон сууцны талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.4.1.орон сууцны асуудлаар төрийн эрх бүхий байгууллагаас боловсруулсан төсөл, хөтөлбөрт санал өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

10.4.2.харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ ОРОН СУУЦ ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**11 дүгээр зүйл.Орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө**

11.1.Орон сууц, түүний дэд бүтцийг шинээр барих, шинэчлэх, өргөтгөх арга хэмжээг орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.

11.2.Орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд төв, суурин газрын гэр хороолол, шинээр баригдах орон сууцны хороолол, барилгажсан хэсэг дэх орон сууцны хорооллыг хамруулна.

11.3.Орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд орон сууц, түүний дэд бүтэц, орчны тохижилт, ногоон байгууламж, нийгмийн үйлчилгээний барилга байгууламжийн байршлыг иж бүрнээр тусгана.

11.4.Орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад дараах шаардлагыг биелүүлнэ:

11.4.1. тухайн нутаг дэвсгэрт орон сууцыг дэд бүтэктэй нь хамт төлөвлөж хөгжүүлэх, орон сууц нэмж барихад түүнийг дэд бүтцийн сүлжээнд үе шаттайгаар холбох;

11.4.2.оршин суугчдын эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах;

11.4.3.хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө, үр дагавар гаргуулахгүй байх;

11.4.4.орон сууцны хорооллын доторх түгээх шугам сүлжээг хонгил, сувагчлалын системээр төлөвлөх;

11.4.5.хуульд заасан бусад.

11.5.Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.

## **12 дугаар зүйл.Орон сууц хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх**

12.1.Орон сууц, түүний дэд бүтцийг хөгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

12.1.1.улсын болон орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө;

12.1.2.олон улсын байгууллага, гадаад улс, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хандив, тусlamж, хөрөнгө оруулалт;

12.1.3.үнэт цаасны арилжаанаас олсон орлого;

12.1.4.хуульд заасан бусад эх үүсвэр.

## **13 дугаар зүйл.Түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх**

13.1.Түрээсийн орон сууц нь төрийн, орон нутгийн, хувийн өмчийн гэсэн хэлбэртэй байна.

13.2.Төрийн өмчийн түрээсийн орон сууцны санг бүрдүүлэх асуудлыг орон сууцны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны санг бүрдүүлэх асуудлыг аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцна.

## **14 дүгээр зүйл.Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгыг буулган шинээр барих**

14.1.Ашиглалтын шаардлага хангахгүй болсон олон айлын орон сууцны барилгыг ашиглахыг хориглоно.

14.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга барилга, хот байгуулалтын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн барилга байгууламжийг ашиглахыг хориглосон шийдвэр гаргана.

14.3.Барилга байгууламжийг ашиглахыг хориглосон шийдвэрийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргаас хүлээн авмагц түүнийг дахин төлөвлөлтэд оруулах тухай сууц өмчлөгчдийн олонхи нь саналаа гаргаж, хүсэлтээ 14 хоногийн дотор тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад хүргүүлнэ.

14.4.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулгах, дахин төлөвлөх шийдвэр гаргана.

14.5.Ашиглалтын шаардлага хангахгүй болсон олон айлын орон сууцны оронд шинээр орон сууцны барилга барих хөрөнгө оруулагч нь аймаг, нийслэлийн Засаг дарга, сууц өмчлөгчидтэй харилцан тохиролцож гэрээ байгуулах бөгөөд уг гэрээнд сууц өмчлөгчдийг нүүлгэн шилжүүлэх, орон сууцаар түр хангах, шинэ орон сууцны ашиглалтад орох хугацаа, талбайн хэмжээ, үнэ, төлбөр, хариуцлагын асуудлыг тусгана.

14.6.Ашиглалтын шаардлага хангахгүй болсон олон айлын орон сууцны сууц өмчлөгчид нь хөрөнгө оруулагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр шинээр баригдах орон сууцнаас эхний эзлжид өмчлөх эрх эдлэх бөгөөд шинээр өмчлөх орон сууцны талбайн хэмжээ хуучин орон сууцны талбайн хэмжээнээс багагүй байна.

14.7.Ашиглалтын шаардлага хангахгүй болсон олон айлын орон сууцны сууц өмчлөгч нь хуучин орон сууцаа хөрөнгө оруулагчтай тохиролцон худалдах, эсхүл нөхөн олговор авах эрхтэй.

14.8.Ашиглалтын шаардлага хангахгүй болсон олон айлын орон сууцыг буулгах, дахин төлөвлөх, шинээр орон сууц барих талаар аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэр гарснаар тухайн орон сууцыг мэдээллийн нэгдсэн сангаас хасаж ашиглах эрх дуусгавар болно.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ОРОН СУУЦНЫ АШИГЛАЛТ**

#### **15 дугаар зүйл. Мэргэжлийн байгууллага**

15.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 8.1.4-т заасан журмын дагуу олон айлын болон нэг айлын орон сууцны хорооллын ашиглалт хариуцах мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж ажиллана.

15.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга мэргэжлийн байгууллагатай 5 жилийн хугацаатай гэрээ байгуулна. Гэрээг 5 жилээр сунгана.

15.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга орон сууцны их болон урсгал засварын төлөвлөгөөг батлах бөгөөд энэ нь мэргэжлийн байгууллагатай байгуулах гэрээний салшгүй хэсэг байна.

15.4.Энэ хуулийн 15.2-т заасан гэрээний хэрэгжилтийг аймаг, нийслэлийн Засаг дарга жил тутамд дүгнэж, гэрээг үргэлжлүүлэх эсхүл цуцлах асуудлыг шийдвэрлэнэ.

15.5.Мэргэжлийн байгууллагатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг энэ хуулийн 10.3.6-д заасан төвд хэрэглэгчээс ирүүлсэн гомдол, саналын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, 15.3-т заасан төлөвлөгөөний биелэлт болон холбогдох байгууллагаас гаргасан дүгнэлтэд үндэслэн дүгнэнэ.

15.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга, сууц өмчлөгчдийн хүсэлтээр мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар хяналт, шалгалт хийлгэж, дүгнэлт гаргуулна.

15.7.Нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 15.1-15.6-д заасан чиг үүргийг холбогдох дүүргийн Засаг даргад шилжүүлэн гүйцэтгүүлж болно.

## **16 дугаар зүйл.Мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл, хориглох зүйл**

16.1.Мэргэжлийн байгууллага дараах үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлнэ:

16.1.1.орон сууцны барилга, түүний хийц, бүтээцийн их болон урсгал засвар;

16.1.2.цахилгаан шатны их болон урсгал засвар, ашиглалт;

16.1.3.ус, дулаан дамжуулах төв, техникийн өрөөний засвар, ашиглалт;

16.1.4.түгээх болон дундын өмчлөлийн шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн техник ашиглалт, аюулгүй ажиллагаа, их болон урсгал засвар;

16.1.5.ус, дулаан, хий, цахилгаан түгээх, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлцуулах, харилцаа, холбооны зэрэг үйлчилгээг энэ хуулийн 19.1-д заасан хэрэглэгчийн тоног төхөөрөмж хүртэл хариуцах;

16.1.6.хэрэглэгчийг шаардлага хангасан унд, ахуйн ус, хий болон цахилгаан, дулаан, харилцаа, холбооны үйлчилгээгээр хангах;

16.1.7.орц, хонгил, гарааш, орчны тохижилт, гэрэлтүүлэг, хяналтын дуран /камер/-ийн засвар, ашиглалт, цэвэрлэгээ, үйлчилгээ;

16.1.8.ахуйн хог хаягдлыг тодорхой цэгт төвлөрүүлэх, татан зайлцуулах;

16.1.9.харуул, хамгаалалт;

16.1.10.хэрэглэгч бүртэй гэрээ байгуулах, уг гэрээний хэрэгжилтийг хариуцах, тайлагнах, гэрээний үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг хариуцах;

16.1.11.байнгын, тасралтгүй ажиллагаатай дуудлага хүлээн авах төвийг ажиллуулах, хэрэглэгчийн хүсэлт, гомдол, саналыг хүлээн авах, барагдуулах ажлыг шуурхай зохион байгуулах;

16.1.12.орон сууцны барилгын хийц, бүтээцэд ан цав, цууралт үүсэх зэрэг ноцтой эвдрэл, гэмтэл гарсан тохиолдолд барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад хандаж, дүгнэлт гаргуулах, холбогдох арга хэмжээг авах;

16.1.13.оршин суугч нь эзгүй үед сууцанд ус, хий алдах, гал гарах зэрэг бусад оршин суугчдын аюулгүй байдал, эд хөрөнгөд хохирол учруулахийц эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд тухайн сууцанд нэвтрэн эвдрэл, гэмтлийг арилгаж болох бөгөөд энэ тухай оршин суугчдын болон цагдаагийн байгууллагын төлөөлөгчийг байлцуулан акт үйлдэж эзгүй байсан оршин суугчийн эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авах;

16.1.14.нийтийн эзэмшил' болон хувийн өмчлөлийн зам, талбайгаар дайран өнгөрөх орон сууцны түгээх шугам сүлжээний хонгил, харилцаа, холбооны сувагчлал гэмтсэн тохиолдолд бусад түгээх шугам сүлжээний хэвийн ажиллагааг алдагдуулахгүйгээр засварлах;

16.1.15.орон сууцны хороололд дуу чимээний үзүүлэх хүчний түвшингийн хэмжилт хийлгэж, зөвшөөрөгдөх хэмжээг давсан тохиолдолд дуу тусгаарлах байгууламж барих асуудлыг холбогдох байгууллагад тавьж, шийдвэрлүүлэх;

16.1.16.дундын өмчлөлд хамаарах инженерийн шугам сүлжээнээс бусад дундын өмчлөлийн эд хөрөнгийг бусдад түрээслүүлэх асуудлаар тухайн орон сууц өмчлөгчдөөс бичгээр санал авч, олонх нь дэмжсэн тохиолдолд гэрээ байгуулж түрээслүүлэх;

16.1.17.энэ хуулийн 17.3-т заасныг зөрчсөн иргэн, хуулийн этгээдийн ус, дулаан, цахилгаан хангамжийг таслах, гарсан хохирлыг нөхөн төлүүлэх, төлөвлөлтийн шаардлагыг хангуулах;

16.1.18.орон сууцны урсгал болон их засварын төлөвлөгөөний төслийг боловсруулах, холбогдох байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх;

16.1.19.барилга угсралтын байгууллагатай хамтран ажиллаж, Барилгын тухай хуулийн 14.7-д заасан шаардлагыг хангуулах;

16.1.20.орон сууцны барилгын хувийн хэрэг хөтлөх.

16.2.Мэргэжлийн байгууллага нь оршин суугчдын саналыг үндэслэн орон сууц, сууцанд мөрдөх оршин суух, дундын өмчлөлийн эд хөрөнгө ашиглах дүрэм баталж болно.

16.3.Мэргэжлийн байгууллага нь энэ хуулийн 16.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох хуульд заасан тусгай зөвшөөрлийг авсан байна.

16.4.Мэргэжлийн байгууллага Сууц өмчлөгчдийн холбоотой гэрээ байгуулж, энэ хуулийн 16.1.7, 16.1.8, 16.1.9-д заасан үйл ажиллагааг гүйцэтгүүлж болно.

16.5.Мэргэжлийн байгууллага нь цахилгаан хангамжийн болон холбоо дохиоллын үйлчилгээг тухайн чиглэлийн эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулж, ашиглалт, засвар, үйлчилгээг гүйцэтгүүлж болно.

16.6.Мэргэжлийн байгууллага энэ хуулийн 16.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд дараах үйл ажиллагааг хориглоно:

16.6.1.орон сууцны орчны зам, талбайн хөдөлгөөнийг засвар, үйлчилгээ хийхээс бусад тохиолдолд хааж, бусдад саад учруулах;

16.6.2.орон сууцны засвар, арчлалтын сангийн хөрөнгийг зориулалтын бусаар ашиглах, зарцуулах;

16.6.3.сууц өмчлөгчдөөс үндэслэлгүй төлбөр, хураамж нэхэмжлэх;

16.6.4.орон сууцны техникийн өрөөний зориулалтыг өөрчлөх;

‘16.6.5.орон сууцны’ дотор агаарын төмпературыг холбогдох норм, дүрэмд тогтоосон хувь хэмжээнээс багасгаж, дулааны эрчим хүчний зүй бус хэмнэлт хийх;

16.6.6.олон айлын орон сууцны орчны газрын зориулалтыг өөрчлөх;

16.6.7.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай, Эрчим хүчний тухай хуулиудад зөвшөөрөгдсөн болон энэ хуулийн 16.1-д зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэх.

## **17 дугаар зүйл.Сууц өмчлөгчийн эрх, үүрэг, хориглох зүйл**

17.1.Сууц өмчлөгч нь дараах эрхтэй:

17.1.1.мэргэжлийн байгууллагаас норм, дүрэм, журам, стандартын шаардлагад нийцсэн үйлчилгээ авах, үйлчлүүлэх;

17.1.2.мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулахад оролцох, үйл ажиллагаанд хяналт тавих;

17.1.3.засвар, үйлчилгээний хөлс, зардал үндэслэлтэй эсэх талаар аймаг, нийслэлийн Засаг даргад гомдол, санал гаргаж шийдвэрлүүлэх;

17.1.4.үндэслэлгүй төлбөр, хураамжийг төлөхөөс татгалзах, учирсан хохирлоо нөхөн тооцуулах;

17.1.5.орон сууцаа сайн дурын даатгалд даатгуулах;

17.1.6.хуульд заасан бусад эрх.

17.2.Сууц өмчлөгч нь дараах үүрэгтэй:

17.2.1.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс баталсан аргачлалын дагуу тогтоосон хураамжийг төлөх;

17.2.2.хангагч байгууллагаар үйлчлүүлсэн үйлчилгээний төлбөр, хураамжийг тогтоосон тарифын дагуу төлөх;

17.2.3.бусдын амгалан, тайван амьдрах нөхцөлийг алдагдуулахгүй байх;

17.2.4.дундын өмчлөлийн эд хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, хамгаалах;

17.2.5.орон сууцны барилга, түүний түгээх шугам сүлжээ, тоног төхөөрөмжид эвдрэл, гэмтэл гарсан тухай бүр мэргэжлийн байгууллагад мэдэгдэж засвар, үйлчилгээ хийх ажилтныг саадгүй нэвтрүүлэх.

17.3.Орон сууцны зориулалт, төлөвлөлт, үндсэн бүтээц, хийцийг анхны зураг төслөөс өөрчлөх, нэмэлт ачаалал өгч давхарлах, өргөтгөл хийхийг хориглоно.

17.4.Олон айлын 2-оос дээш давхар орон сууцанд савласан ахуйн хий хадгалах, ашиглахыг хориглоно.

## **18 дугаар зүйл.Сууц өмчлөгчдийн холбоо**

18.1.Тухайн орон сууцны болон гэр хорооллын гудамжны оршин суугчид өөрсдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор сайн дураараа эвлэлдэн нэгдэж, Сууц өмчлөгчдийн холбоог байгуулж болно.

18.2.Сууц өмчлөгчдийн холбоо нь мэргэжлийн байгууллагын чиг үүрэгт хамаарахгүй дараах үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэж болно.

18.2.1.мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих, үйл ажиллагаанд хяналт тавих, санал, гомдоо илэрхийлэх, шийдвэрлүүлэх, төрийн байгууллагын дэмжлэгийг авах;

18.2.2.мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулахад төлөөллөө оролцуулах;

18.2.3.орон сууцны ашиглалт, орон сууц, гэр хорооллын орчны тохижилт, амьдрах нөхцөлөө сайжруулах чиглэлээр оршин суугчдын идэвх, санаачилгыг өрнүүлэх, мод тарих, нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах.

## **19 дүгээр зүйл.Олон айлын орон сууцанд хамаарах өмчлөлийн зүйл**

19.1.Олон айлын орон сууцны сууц өмчлөгчийн дангаар өмчлөх өмчлөлийн зүйлд Иргэний хуулийн 146.1-д заасан бүрдэл хэсэг болон хэрэглэгчийн тоног төхөөрөмж хамаарна.

*Тайлбар: Хэрэглэгчийн тоног төхөөрөмжид тухайн сууцны доторх халаах хэрэгсэл, ванн, душ, угаагуур, жорлон, алчуур хатаагч, агаар сэлгэлтийн тоноглол, цахилгааны тоноглол /залгуур, унтраалга г.м./, холбоо, дохиоллын тоноглол /домофон, галын дохиоллын төхөөрөмж г.м./ тэдгээрээс эхний хаалт /вентиль/, таслуур хүртэлх салбар шугам сүлжээ хамаарна.*

19.2.Сууц өмчлөгчдийн дундын өмчлөлийн эд хөрөнгөд орон сууцны гадна хана, даацын хана, багана, доод хонгил, дээвэр, дээврийн хонгил, агааржуулалтын хоолой, түүний тоног төхөөрөмж, гал эсэргүүцэх тоноглол, цахилгаан болон явган шат, аваарын шат, шатны хонгил, техникийн өрөө, сууц хоорондын талбай, тагт, автомат цоож, хяналтын дуран /камер/, орцны цонх, хаалга, довжкоо, саравч, хог зайлуулах хоолой, тухайн орон сууцны дээрх болон доорх нийтийн зориулалттай усан сан, сууцны доторх дундын өмчлөлийн зүйл, тоног төхөөрөмж, халаалт болон халуун, хүйтэн усны шугам сүлжээний удирдах зангилааны анхны хаалт, шалны +0.00 тэмдэгтээс дээшхи бохир усны шугам сүлжээнүүд, тухайн орон сууцанд хамаарах харилцаа, холбооны сувагчлал, оршин суугчдад зориулагдсан ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, сүүдрэвч, гэрэлтүүлэг, тэдгээртэй адилтгах байгууламж, олон айлын орон сууцны доорх газар зэрэг эд хөрөнгө хамаарна.

*Тайлбар: "техникийн өрөө" гэж орон сууцны түгээх шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг байрлуулахад зориулсан, тусгаарласан өрөөг хэлнэ.*

19.3.Олон айлын орон сууцны ус, дулаан, хий түгээх сүлжээ, бохир ус цуглуулах шугам сүлжээ, эрчим хүчний дэд станц, шугам, тоноглол, түгээх сүлжээнд хамаарах харилцаа холбооны худаг, сувагчлал, орон сууцны хорооллын доторх

явган хүний болон автомушины зам, тэдгээртэй адилтгах барилга, байгууламж орох нутгийн өмчид байна.

19.4.Орон сууцны захиалагч, хөрөнгө оруулагч энэ хуулийн 19.3-т заасан эд хөрөнгийн ашиглалтын хэвийн ажиллагааг хангаж, орон нутгийн өмчид шилжүүлэх ажлыг хариуцна.

19.5.Орон сууцны доорх газар нь энэ хуулийн 19.2 дахь хэсэгт заасны дагуу сууц өмчлөгчдийн дундын өмч бөгөөд орон сууцны ашиглалтын хугацаа дуусах, эсхүл нурах, эвдрэх, устах тохиолдолд үүсэх харилцааг Иргэний хууль, Газрын тухай хуульд зааснаар зохицуулна.

## **20 дугаар зүйл.Орон сууцны засвар, арчлалтын сан**

20.1.Мэргэжлийн байгууллага нь Орон сууцны засвар, арчлалтын сангийн хөрөнгийн дансыг орон сууцны барилга бүрээр хөтөлж, өөрийн хөрөнгөөс тусгаарлан, зориулалтын дагуу захиран зарцуулна.

20.2.Орон сууцны засвар, арчлалтын сангийн хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

20.2.1.төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт;

20.2.2.сангийн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү;

20.2.3.санд оруулсан хандив, тусламж;

20.2.4.Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс баталсан аргачлалын дагуу тогтоосон хэмжээгээр оршин суугч болон тухайн орон сууцанд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хуримтлуулах мөнгөн хөрөнгө;

20.2.5.хангагч байгууллагаас төвлөрүүлэх орон сууцны түгээх болон дундын өмчлөлийн шугам сүлжээг ашиглан борлуулсан бүтээгдэхүүний төлбөрт ногдох шимтгэл;

20.2.6.дундын өмчлөлийн эд хөрөнгийг хөлслүүлсэн, түрээслүүлсний орлого;

20.2.7.хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

20.3.Мэргэжлийн байгууллага нь Орон сууцны засвар, арчлалтын сангийн үйл ажиллагааны тайлангаа аймаг, нийслэлийн Засаг даргад улирал бүр тайлagnана.

20.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга Орон сууцны засвар, арчлалтын сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланда жил бүр хөндлөнгийн аудит хийлгэж, дүгнэлт гаргуулна.

## **21 дүгээр зүйл.Орон сууцанд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх**

21.1.Орон сууцны үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар баригдсан хэсэгт болон оршин суугчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүйгээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж болно.

21.2.Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь хууль тогтоомжид заасан журмын дагуу эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрлийг авсан байна.

21.3.Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь сууц өмчлөгчийн эрхийг шууд болон шууд бус хэлбэрээр хязгаарлахыг хориглоно.

21.4.Орон сууцанд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд дундын өмчлөлийн эд хөрөнгөд засвар, үйлчилгээ хийх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

21.5.Орон сууцанд барилгын төлөвлөлт, эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын норм зөрчсөн дор дурдсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хориглоно:

21.5.1.химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх, хадгалах, худалдах, ашиглах, устгах;

21.5.2.ахуйн хэрэглээнд шаардагдахаас бусад тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, галд амархан шатдаг материал үйлдвэрлэх, хадгалах, худалдах;

21.5.3.хурц үнэртэй материал, бодис хадгалах, худалдах;

21.5.4.цацрагийн үүсгүүр, цацрагийн үүсгүүр бүхий багаж, тоног төхөөрөмж, стандартын шаардлага хангаагүй цахилгаан соронзон орон үүсгүүр, нянгийн амьд өсгөвөр, пестицид ашиглах;

21.5.5.даралтат сав, уурын тоног төхөөрөмж ашиглах;

21.5.6.арьс шир, түүхий эд хүлээн авах, худалдах;

21.5.7.зориулалтын бус байранд саун, нийтийн халуун усны болон угаалгын газар, хими цэвэрлэгээ, эмнэлгийн салбар, нийтийн бие засах газар, нийтийн хоолны газар, цахим тоглоомын газар ажиллуулах;

21.5.8. 40 децибилл /dB/-аас их хэмжээний дуу чимээ гаргах;

21.5.9.хууль тогтоомжоор хориглосон бусад үйлдвэрлэл, үйлчилгээ.

## ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

### 22 дугаар зүйл.Маргаан хянан шийдвэрлэх

22.1.Мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гомдлыг харьяалах төрийн байгууллагад болон барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад гаргана.

22.2.Энэхүү хуультай холбоотой гомдол гаргах, хянан шийдвэрлэх асуудлыг холбогдох хуульд заасны дагуу зохицуулна.

22.3.Үнэ, тариф, төлбөр, хураамжийн талаар хэрэглэгчээс гаргасан гомдол, маргааныг холбогдох байгууллага хянан шийдвэрлэж, хариу өгөх үүрэгтэй.

### 23 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

23.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

23.2.Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

#### **24 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

24.1.Энэ хуулийг 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

#### **ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ИРГЭНИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Иргэний хуулийн 143 дугаар зүйлийн 143.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/143 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“143.1. Олон айлын орон сууцны ашиглалт, орон сууц, гэр хорооллын орчны газрын тохижилтыг сайжруулах зэргээр өөрсдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор сайн дураараа эвлэлдэн нэгдсэн, Иргэний хуулийн 481 дүгээр зүйлд заасны дагуу зохион байгуулагдсан оршин суучдын бүртгэгдээгүй холбоог байгуулж болно.”

**2 дугаар зүйл.** Иргэний хуулийн 143 дугаар зүйлийн 143.5 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/143 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“143.5. Орон сууцны бүрэлдэхүүнд төрийн болон орон нутгийн өмчийн сууц байгаа бол өмчлөгчийн эрх бүхий байгууллагаас томилсон төлөөлөгч холбооны гишигийн байж болно.”

**3 дугаар зүйл.** Иргэний хуулийн дор дурдсан зүйлийн агуулгыг 147 дугаар зүйлийн 147.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/147 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“147.1. Сууц өмчлөгч нь өөрийн өмчлөлд байгаа сууц болон сууцны бус зориулалттай хэсгийн халаалт, халуун, цэвэр, бохир ус, ариутгал, хог, цахилгаан, холбоо зэрэг орон сууцны ашиглалтын төлбөр, дундын өмчлөлийн зүйлийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардлыг эрх бүхий байгууллагад төлнө.”

**4 дүгээр зүйл.** Иргэний хуулийн 143 дугаар зүйлийн 143.2-143.4, 143.6 дугаар хэсэг, 144, 149 дүгээр зүйл болон 147 дугаар зүйлийн 147.6 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг Орон сууцны тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд дараах нэмэлтийг оруулсугай.

1/10 дугаар зүйлийн 10.1.10 дахь заалт:

“10.1.10.олон айлын орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээнд зориулж оршин суугчаас болон тухайн орон сууцанд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас төвлөрүүлэх хураамжийн хэмжээг тогтоох аргачлалыг боловсруулж батлах, хэрэгжилтэд хяналт тавих” гэж;

2/10 дугаар зүйлийн 10.1.11 дэх заалт:

“10.1.11.мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны бодит зардал, саналыг үндэслэн орон сууцанд хийгдэх засвар, үйлчилгээний жишиг тариф батлах” гэж;

3/10 дугаар зүйлийн 10.1.12 дахь заалт:

“10.1.12.мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны талаар дүгнэлт гаргах” гэж;

4/10 дугаар зүйлийн 10.1.13 дахь заалт:

“10.1.13.олон айлын орон сууцны дундын өмчлөлд хамаарах эд хөрөнгө, түгээх шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмж, тэдгээртэй холбогдох байгууламж, орчны тохижилтын байгууламж, хорооллын доторх явган хүний болон автомашины зам, түүнтэй адилтгах байгууламж зэрэг эд хөрөнгөд элэгдэл тооцох журмыг боловсруулж, батлах” гэж;

4/19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “... цэвэр ус дамжуулах, түгээх” гэсний дараа “цэвэр усны оруулгын” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Орон сууцны тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8 дахь заалтын “сууц өмчлөгчдийн холбоог” гэснийг “мэргэжлийн байгууллагыг” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Орон сууцны тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“6.4.Олон айлын орон сууцны оршин суугчдад зориулагдсан ногоон зүлэг, мод, бут, сөөг, хүүхдийн тоглоомын талбай, сүүдрэвч зэрэг байгууламжийг арчлан хамгаалах зориулалтаар мэргэжлийн байгууллагад ашиглуулж болно.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Орон сууцны тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ОРОН СУУЦ ХУВЬЧЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Орон сууц хувьчлах тухай хуулийн 2 дугаар зүйлийн "Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай" гэснийг "Орон сууцны тухай" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Орон сууц хувьчлах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Орон сууцны тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 100 дугаар зүйлийн 100.5 дахь хэсгээс "холбооны" гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Орон сууцны тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### **СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, НИЙТИЙН ЗОРИУЛАЛТАЙ ОРОН СУУЦНЫ БАЙШИНГИЙН ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**2003 оны 6 сарын 18-ны өдөр батлагдсан Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцусгай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Орон сууцны тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр баталсан Орон сууцны тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Орон сууцны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ОРОН СУУЦНЫ ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Орон сууцны тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 19.3-т заасан ашиглагдаж байгаа эд хөрөнгийг орон нутгийн өмчлөлд шилжүүлэхтэй холбогдох ажлыг Аймаг, нийслэлийн Засаг дарга Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлтэй хамтран энэ хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш нэг жилийн дотор хариуцан зохион байгуулна.

**2 дугаар зүйл.** Аймаг, нийслэлийн Засаг дарга дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, засвар, үйлчилгээнд зориулж, сууц өмчлөгчдөөс хурийтлуулсан хөрөнгийг Орон сууцны тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин өдөр болсон өдрөөр тооцож Орон сууцны засвар арчлалтын санд шилжүүлнэ. Эр, авлагын тооцоо нийлж, хариуцагчийн гүйцэтгээгүй үүргийг гүйцэтгүүлэх арга хэмжээ авна.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан эд хөрөнгийг орон нутгийн өмчлөлд шилжүүлэн авахад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөнө.

**4 дүгээр зүйл.** Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш шинээр бий болсон Орон сууцны тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 19.3 дахь хэсэгт заасан хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэн авч, мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулж, үйл ажиллагааг нь эхлүүлэх ажлыг Орон сууцны тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн дагуу зохион байгуулна.

**5 дугаар зүйл.** Энэ хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш 6 сарын дотор аймаг, нийслэлийн Засаг дарга орон сууцны ашиглалт үйлчилгээг эрхэлж буй орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудтай гэрээг 5 жилийн хугацаатай байгуулж, гэрээт хугацаанд хэрэгжүүлэх их болон урсгал засварын төлөвлөгөөг баталж өгөх бөгөөд Орон сууцны тухай /Шинэчилсэн найруулга/ хуульд заасан хугацаанд гэрээний хэрэгжилтийг дүгнэж, хариуцлага тооцож ажиллана.

**6 дугаар зүйл.** Орон сууцны тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан “Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ”-г Барилгын тухай хуулийн 33.1.10-д заасны дагуу Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталж хэрэгжүүлнэ.

**7 дугаар зүйл.** Энэ хуулийг Орон сууцны тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### ГАРЫН ҮСЭГ